

**ТАМХИНЫ ХЯНАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН
ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЭСЭХ ТАЛААР НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН ХОРООНООС ГАРГАСАН
САНАЛ, ДҮГНЭЛТ**

2014 оны 6 дугаар
сарын 18-ны өдөр

Улаанбаатар
хот

Илтгэгч нь: Улсын Их Хурлын гишүүн Ж.Батсуурь

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын гишүүн Д.Эрдэнэбатаас 2014 оны 6 дугаар сарын 11-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг тус Байнгын хороо 2014 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төсөлд утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг тодорхойлж, байгуулах, тамхи татах зориулалтаар тусгайлан бэлтгэж өгсөн талбайг гадаа, агааржуулалтын тоног төхөөрөмжөөр тоноглогдсон тусгаарласан тасалгааг дотор байхаар зааж, дээрх зөвшөөрөгдсөн цэгүүдэд тэмдэг байрлуулахаар тусгажээ.

Түүнчлэн нийтийн хоол, худалдаа, баар, цэнгээний газар, аж ахуйн нэгж, байгууллагын ажлын байрны дотоод орчин болон нийтийн эдэлбэр газарт тамхи татах зөвшөөрөгдсөн цэг байгуулж, тухайн зөвшөөрөгдсөн цэгийн байршил, төсвийг сум дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, хэрэв аж ахуй нэгж, байгууллага байгуулах бол тухайн хуулийн этгээд өөрөө хариуцахаар тусгасан байна.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүн Л.Эрдэнэчимэг төсөлд зөвхөн тамхи татдаг хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашгийг хамгаалсан заалтууд тусгагдсан тул уг хуулийн төслийг эсэргүүцэж байгаагаа илэрхийлсэн, Улсын Их Хурлын гишүүн О.Баасанхүү хуулийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулахад зарим харилцаа зохицуулагдаагүй байгааг анхаарах, төсвийн хөрөнгөөр утаат тамхи татах зөвшөөрөгдсөн цэгийг байгуулахад шаардлагатай эдийн засгийн тооцоог тодорхой болгож гишүүдэд мэдээлэл өгөх, Улсын Их Хурлын гишүүн Д.Сумъяабазар хуулийг хэрэгжүүлэхэд тавих хяналтын механизмыг сайжруулах, хууль тогтоогчдоос эхлэн хуулиа чандлан сахиж, иргэдэд үлгэр дуурайл үзүүлдэг байх нь зүйтэй гэсэн саналуудыг тус тус гаргасан болно.


Тус Байнгын хорооны хуралдаанаар Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэсэн саналаар санал хураалт явуулахад хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй болно.

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Нийгмийн бодлого, боловсрол, соёл, шинжлэх ухааны байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

НИЙГМИЙН БОДЛОГО, БОЛОВСРОЛ,
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



Д.БАТЦОГТ